

UCS 1703A:2022

# ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ




Аюултай хог хаягдлын менежмент



# ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Аюултай хог хаягдлын менежмент

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 25-р тогтоолоор батлав.*



## ГАРЧИГ

|  |    |
|--|----|
| 1. Хамрах хүрээ .....  | 5  |
| 2. Норматив эшлэл .....  | 5  |
| 3. Нэр томъёоны тодорхойлолт .....   | 6  |
| 4. Аюултай хог хаягдлын төрөл, ангилал .....   | 7  |
| 5. Аюултай хог хаягдлын таних тэмдэг .....   | 9  |
| 6. Аюултай хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах .....                            | 10 |
| 7. Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх .....                                    | 13 |
| 8. Аюултай хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага ..... | 14 |
| 9. Аюултай хог хаягдал хүлээн авах .....   | 15 |
| 10. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах .....                           | 17 |
| 11. Аюултай хог хаягдал устгах .....   | 20 |
| 12. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент .....                          | 22 |
| 13. Шалгуур үзүүлэлт .....   | 24 |
| Ашигласан материал .....   | 25 |
| Хавсралт 1. Аюултай хог хаягдлын ангилал .....                                       | 26 |

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

|  |    |
|--|----|
| Зураг 1. Өдрийн гэрэл .....  | 8  |
| Зураг 2. Зай хураагуур .....   | 8  |
| Зураг 3. Аккумулятор .....   | 8  |
| Зураг 4. Батарей .....   | 8  |
| Зураг 5. Хортой бодис агуулсан мод, модон эдлэл .....                          | 8  |
| Зураг 6. Хортой бодис агуулсан цахилгаан болон цахим төхөөрөмж, хэрэгсэл ..... | 8  |
| Зураг 7. Хортой бодис агуулсан будаг, бэх, цавуу, резин .....                  | 8  |
| Зураг 8. Хортой бодис агуулсан угаалгын бодис, нунтаг .....                    | 8  |
| Зураг 9. Мөнгөн ус агуулсан хаягдал .....                                      | 8  |
| Зураг 10. Цуглуулах, устгахад тусгай шаардлага тавигддаг .....                 | 8  |
| Зураг 11. Зуухны доод үнс, яндангийн хөө .....                                 | 8  |
| Зураг 12. Автомашинны батарей .....  | 8  |
| Зураг 13. Аюултай бараа бүтээгдэхүүний таних тэмдэг .....                      | 9  |
| Зураг 14. Хортой хог хаягдал .....   | 10 |
| Зураг 15. Химийн хог хаягдал .....   | 10 |
| Зураг 16. Цөмийн хог хаягдал .....   | 10 |
| Зураг 17. Эмнэлгийн үйлчилгээний хог хаягдал .....                             | 10 |
| Зураг 18. Химийн цацраг идэвхтэй хаягдал .....                                 | 10 |
| Зураг 19. Халдварын зэрэглэл өндөртэй хаягдал .....                            | 10 |
| Зураг 20. Аюултай хог хаягдал түр хадгалах сав .....                           | 11 |
| Зураг 21. Аюултай хог хаягдал хадгалах савны шошго .....                       | 11 |
| Зураг 22. Гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах .....                          | 12 |

|   |    |
|---|----|
| Зураг 23. Аюултай хог хаягдал цуглуулах болон устгах схем .....   | 13 |
| Зураг 24. Битүү бүхээгтэй тээврийн хэрэгсэл .....   | 14 |
| Зураг 25. Цистерн тээврийн хэрэгсэл .....   | 14 |
| Зураг 26. Нээлттэй тэвштэй тээврийн хэрэгсэл .....  | 14 |
| Зураг 27. Аюултай ачаа таних тэмдгийн хэмжээ.....   | 14 |
| Зураг 28. Орохыг хориглоно .....  | 15 |
| Зураг 29. Галын хор.....  | 15 |
| Зураг 30. Хувийн хамгаалах хэрэгсэл .....   | 15 |
| Зураг 31. Дугуйн ивүүр 2-оос тэмдэг /2 ширхэг/ цөөнгүй .....  | 15 |
| Зураг 32. Аюултай хог хаягдлын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий<br>байгууллагын үйл ажиллагааны зураглал ..... | 17 |
| Зураг 33. Агуулахын байршлын төлөвлөлт .....  | 18 |
| Зураг 34. Задгай агуулахад хадгалах аюултай хог хаягдал .....   | 18 |
| Зураг 35. Хувийн хамгаалах хэрэгсэл .....   | 19 |
| Зураг 36. Аюултай хог хаягдлын ландфилл .....   | 20 |
| Зураг 37. Аюултай хог хаягдал шатаах зуух .....   | 21 |
| Зураг 38. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ангилал .....   | 22 |
| Зураг 39. Эмнэлгийн хог хаягдлыг ангилан ялгах уут, савны өнгө .....  | 22 |
| Зураг 40. Эмнэлгийн тусгай хог хаягдал устгах үйл ажиллагаа .....   | 23 |

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

|  |    |
|--|----|
| Хүснэгт 1. Аюулын шинж чанар .....                           | 7  |
| Хүснэгт 2. Анхааруулах тэмдгийн хэмжээ байршил .....         | 9  |
| Хүснэгт 3. Аюултай хог хаягдлын дагалдах бичиг /маягт/ ..... | 16 |
| Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлт .....                            | 24 |



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Г Хог хаягдлын менежментэд хамаарах хотын стандартыг батлах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1.1</sup> дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Хог хаягдлын менежмент бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1703A:2022 “Аюултай хог хаягдлын менежмент” хотын стандарт

1.2. UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандарт

1.3. UCS 1706A:2022 “Барилгын хог хаягдлын менежмент” хотын стандарт

1.4. UCS1704A:2022 “Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны менежмент” хотын стандарт

1.5. UCS1705A:2022 “Хог хаягдлын устгалын стандарт, устгалын удирдамж” хотын стандарт

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.


3. Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100325



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 25  
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

### UCS 1703A:2022 “АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ” ХОТЫН СТАНДАРТ

#### 1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ стандартыг аюултай хог хаягдлыг ангилах, тээвэрлэх, хадгалах, болон устгах үйл ажиллагаанд ашиглана.

#### 2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- Хог хаягдлын тухай хууль;
- Хот байгуулалтын тухай хууль;
- Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар тушаал);
- Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам (Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол);
- Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах түр журам (Эрүүл мэндийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2011 оны А-320/305 тоот тушаал);
- Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах заавар (Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158 тоот тушаал);
- БНБД 21-01-02 Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм дүрэм;
- БНБД 21-04-05 Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл;
- MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис хадгалах бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага;
- MNS 6342 : 2012 Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS 5029:2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодсын шошго, анхааруулах тэмдэг;
- MNS 5566:2005 Аж ахуй нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага;
- MNS:5344 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
- MNS ISO 3833:2010 Авто тээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт
- MNS 6593:2016 Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэлт. Нэр томьёо, тодорхойлолт;
- MNS 4978:2017 Аюултай ачаа. Ангилал.Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм.

### 3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

**Хог хаягдал** - гэж өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материал;

**Аюултай хог хаягдал** – гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдал;

**Аюултай хог хаягдал үүсгэгч** – гэж үйл ажиллагаа болон үйлдвэрлэлээс нь аюултай хог хаягдал үүсдэг аж ахуйн нэгж, байгууллага;

**Аюултай хог хаягдал хүлээн авагч** - гэж аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч;

**Аюултай хог хаягдлын дагалдах бичиг** – гэж батлагдсан журмын дагуу бөглөж, гарын үсэг зурж, баталгаажуулсан тээврийн баримт бичиг;

**Аюултай хог хаягдал хариуцсан ажилтан** - гэж хэвийн болон аюул, осол гарсан үед аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах ажилтан;

**Аюултай эд анги агуулсан бүтээгдэхүүн** - гэж бүтнээрээ байхдаа аюултай шинж чанаргүй боловч, задалж салгасны дараа зарим хэсэг нь аюултай шинж чанартай хог хаягдал үүсгэдэг эд юмс;

**Аюултай хог хаягдал алдагдах** - гэж аюул, ослын үед аюултай хог хаягдал хөрс, ус руу асгарах, алдагдах, эсвэл зориудаар аюултай хог хаягдлыг хөрс, ус руу хаях, асгах, нийлүүлэх, шахах, ялгаруулах;

**Энгийн хог хаягдал** – гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдал;

**Ахуйн хог хаягдал** – гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдал;

**Тусгай хог хаягдал** – гэж эрүүл мэндийн байгууллагын оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний явцад үүсэх хүн, амьтны бие, эрхтэн, эд, хэсэг, бичил биетийн өсгөвөр, цус, бусад шингэн, ялгадас, эм, эмийн бүтээгдэхүүн, био бэлдмэл, зүү, тариур, хурц үзүүртэй, иртэй багаж хэрэгсэл, химийн болон цацраг идэвхт бодис зэрэг хог хаягдал;

**Химийн хорт бодис** – гэж хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдэл;

**Химийн аюултай бодис** – гэж тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, мэдрэмтгий шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдэл;

**Хог хаягдлыг шатаах** – гэж хог хаягдлыг зориулалтын байгууламжид шатааж, задлах;

**Хог хаягдлыг булшлах** – гэж хог хаягдлыг газарт булж хадгалах;

**Биологийн боловсруулалт** – гэж бичил биетээр бохирдуулагчийг устгах болон хоргүйжүүлэх;

**Хими-физикийн боловсруулалт** – гэж химийн болон физикийн боловсруулалтыг хослуулан хэрэглэх;

**Химийн боловсруулалт** – гэж химийн бодис ашиглаж хоргүйжүүлэх;

Физикийн боловсруулалт – гэж шүүх, тунадасжуулах, шингээх, нэрэх зэрэг аргаар бохирдуулагчийг цэвэрлэх;

**Халдваргүйжүүлэх** – гэж химийн болон физикийн аргаар халдвартай бичил биетийг устгах;

**Аюултай хог хаягдал алдагдах** – гэж аюул, ослын үед аюултай хог хаягдал хөрс, ус руу асгарах, алдагдах, эсхүл зориудаар аюултай хог хаягдлыг хөрс, ус руу хаях, асгах, нийлүүлэх, шахах, ялгаруулах;

**Анхааруулах тэмдэг** – гэж хор аюулын талаарх мэдээллийн хамгийн товч байдлаар дамжуулах график дүрслэл;

**НҮБ-ын дугаар (UN number)** – гэж олон улсын тээвэрлэлтэд ашиглах зорилгоор химийн хорт болон аюултай бодисыг дугаарласан 4 оронтой тоо;



**Аюулын тэмдэглэгээ** – гэж тухайн аюултай хог хаягдлын хор аюулын шинж чанар, аюулын түвшин илэрхийлсэн тэмдэглэгээ;

**Аюултай хог хаягдал тээвэрлэгч** – гэж аюултай хог хаягдлыг үүсгэгч болон өмчлөгчөөс тээврийн хэрэгслээр хүлээн авагчид хүргэх үйл ажиллагаа эрхлэгч;

**Аюулын тэмдэглэгээ** – гэж тухайн аюултай хог хаягдлын хор аюулын шинж чанар, аюулын түвшинг илэрхийлсэн тэмдэглэгээ;

**Аюултай хог хаягдлын паспорт** – гэж хог хаягдлын бүтцийн талаархи мэдээллийг агуулсан, ямар төрөл аюулын зэрэглэлтэй хог хаягдалд хамаарахыг тогтоосон, түүнийг тээвэрлэх, хадгалах, устгах, технологийг тусгасан эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичиг;

**Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг** – гэж бүтээгдэхүүн материалыг үйлдвэрлэснээс эхлээд устгах хүртэлх хугацаа.

#### 4. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ТӨРӨЛ, АНГИЛАЛ<sup>1</sup>

- 4.1. Хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх аюулын шинж чанараар нь “аюултай”, “хяналттай” болон “энгийн” гэж зэрэглэнэ;
- 4.2. Аюултай хог хаягдлыг үндсэн аюулын шинж чанараар нь шатамхай, идэмхий, урвалд оромтой, хортой гэж ангилна;
- 4.3. Хог хаягдлыг эх үүсвэр, төрлөөр нь ангилж кодчилох ба аюулын шинж чанараас нэг болон хэд хэдэн шинж чанарыг зэрэг агуулж байвал аюултай хог хаягдал гэж үзэх ба Хүснэгт 1-д үзүүлэв (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар тушаал).

Хүснэгт 1. Аюулын шинж чанар

| НҮБ-ын ангилал | Аюулын код | Шинж чанар                      | Тайлбар   |
|----------------|------------|---------------------------------|---|
| 1              | H1         | Тэсрэмтгий                      | Орчны юмсыг гэмтээх хэмжээний хурд, даралт, температур бүхий хий ялгаруулдаг химийн урвалд өөрөө орох чадвар бүхий хатуу, шингэн бодис, хаягдал (эсхүл бодис, хаягдлын хольц) |
| 3              | H3         | Шатамхай (шингэн)               | Битүү саванд 60,5°C, задгай саванд 65,6°C-аас ихгүй температурт шатамхай уур ялгаруулдаг шингэн, шингэний хольц, суспенз  |
| 4.1            | H4.1       | Шатамхай (хатуу)                | Тээвэрлэлтийн явцад амархан шатдаг эсхүл үрэлтийн улмаас өөрөө шатдаг, тэсрэмтгий бодисын ангилалд хамаардаггүй хатуу бодис, тэдгээрийн хаягдал                               |
| 4.2            | H4.2       | Өөрөө идэвхжиж шатдаг           | Тээвэрлэлтийн явцад хэвийн нөхцөлд аяндаа халснаас эсхүл агаартай харилцан үйлчилж халалт үүссэнээс гал авалцдаг бодис, хаягдал   |
| 4.3            | H4.3       | Норвол шатамхай хий ялгаруулдаг | Устай харилцан үйлчилснээс аяндаа шатдаг эсхүл шатамхай хийг аюултай хэмжээгээр ялгаруулдаг бодис, хаягдал  |
| 5.1            | H5.1       | Исэлдүүлэгч                     | Өөрөө шатамхай шинж чанартай биш боловч ихэвчлэн хүчилтөрөгч ялгаруулж бусад материалын шаталтыг тэтгэдэг бодис, хаягдал  |
| 5.2            | H5.2       | Органик хэт исэл                | Хоёр валенттай -0-0- гэсэн бүлэг агуулсан, дулаанд тогтвортой биш, дулаан ялгаруулж өөрөө задардаг бодис, хаягдал.  |
| 6.1            | H6.1       | Онцгой хортой                   | Амьсгалах, залгих, арьс салстаар хүрэлцэх замаар хүний биед ороход хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлдэг, үхэлд хүргэх аюултай бодис, хаягдал  |

<sup>1</sup> Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд учрах эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс аюултай хог хаягдлыг энгийн хог хаягдалтай болон бусад төрлийн аюултай хог хаягдлуудыг хооронд нь холихыг хориглодог.

|     |      |   |  |
|-----|------|---|--|
| 6.2 | H6.2 | Халдвартай  | Хүн болон амьтныг өвчлүүлдэг нь тогтоогдсон эсхүл өвчлүүлэх чадвартай бичил биет болон микробын хор агуулсан бодис, хаягдал  |
| 8   | H8   | Идэмхий   | Химийн урвалын нөлөөгөөр амьд организмын эд эрхтэнтэй шууд хүрэлцэхэд ноцтой гэмтэл учруулдаг эсхүл асгарсан алдагдсан үед бусад эд материал болон тээврийн хэрэгсэлд гэмтэл, эвдрэл үзүүлдэг бодис, хаягдал                     |
| 9   | H.10 | Агаар эсхүл устай харилцан үйлчлэхэд хортой хий ялгаруулдаг | Агаар эсхүл устай харилцан үйлчилснээс хортой хийг аюултай хэмжээгээр ялгаруулдаг бодис, хаягдал   |
| 9   | H11  | Архаг хордлого өгдөг (хорт хавдар үүсгэдэг)                 | Амьсгалах, залгих, арьс салстаар хүрэлцэхэд урт хугацаанд архаг хордлого өгдөг, хорт хавдар үүсгэдэг, үр удамд нөлөөлдөг бодис, хаягдал  |
| 9   | H12  | Байгаль орчинд хортой                                       | Биотод хортой нөлөө үзүүлэх, био хуримтлал үүсгэх замаар хүрээлэн буй орчинд түргэн болон урт хугацааны нөлөөлөл үзүүлдэг бодис, хаягдал   |
| 9   | H13  | Устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг       | Устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг бодис, хаягдал. Жишээ нь: аюултай шинж чанартай шүүрэл Ахуйн аюултай хог хаягдал (түүнтэй найрлага, бүтцийн хувьд ижил үйлдвэр, үйлчилгээ, албан байгууллагын хог хаягдал) |



Зураг 1. Өдрийн гэрэл




Зураг 2. Зай хураагуур




Зураг 3. Аккумулятор



Зураг 4. Батарей



Зураг 5. Хортой бодис агуулсан мод, модон эдлэл



Зураг 6. Хортой бодис агуулсан цахилгаан болон цахим төхөөрөмж, хэрэгсэл



Зураг 7. Хортой бодис агуулсан будаг, бэх, цавуу, резин



Зураг 8. Хортой бодис агуулсан угаалгын бодис, нунтаг



Зураг 9. Мөнгөн ус агуулсан хаягдал



Зураг 10. Цуглуулах, устгахад тусгай шаардлага тавигддаг халдвартай хаягдал



Зураг 11. Зуухны доод үнс, яндангийн хөө



Зураг 12. Автомашинь батарей

## 5. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ТАНИХ ТЭМДЭГ<sup>2</sup>

5.1. Аюултай хог хаягдлыг ангилахдаа үйлдвэрлэхээс эхлэн эцсийн аргаар зайлуулах, нөхөн сэргээх хүртэлх үйл ажиллагаанд аюултай бодис, бэлдмэлийг ангилах, шошголох системд үндэслэн бүртгэл хөтлөлтийг ашиглана.



Зураг 13. Аюултай бараа бүтээгдэхүүний таних тэмдэг (Жишээ зураг)

5.2. Анхааруулах тэмдэг нь тээврийн хэрэгсэл, агуулах, ажлын байр, сав баглаа боодлын хэмжээнээс хамаарсан Хүснэгт 2 -т заасан хэмжээтэй байх ба тэмдэг байрлуулах байршлыг тодорхой заасан байдаг (MNS 5029:2011, 5).

Хүснэгт 2. Анхааруулах тэмдгийн хэмжээ байршил

| № | Тэмдгийн байрлал   | Хэмжээ, мм   | Байршил   |
|---|--|--|---|
| 1 | Тээврийн хэрэгсэлд   | 250x250 мм буюу түүнээс дээш   | 1. Төмөр замын вагон/цистерн, чингэлгийн 2 хажуу тал дээр;<br>2. Авто тээврийн хэрэгслийн 2 хажуу тал болон ар тал дээр;<br>3. Анхааруулах тэмдэг байрлуулах хангалттай гадаргуугүй тээврийн хэрэгслийн хувьд тээвэрлэж буй ачаан дээр харагдахуйцаар ил байрлуулсан байна. |
| 2 | Агуулах, ажлын байранд   | 250x250 мм буюу түүнээс дээш (10м-ийн зайнаас уншигдах боломжтой байх) | 1. Бодис ашиглаж буй ажлын байрны дотор хана;<br>2. Хадгалж буй агуулахын гадна ба дотор хана;  |
| 3 | 5 л эсхүл 5 кг -аас их хэмжээгээр савлагдсан сав, баглаа боодолд   | 100x100 мм буюу түүнээс дээш   | 1. Сав баглаа боодол бүр дээр;<br>2. 450 л эсхүл 450 кг -аас ихээр савлагдсан сав, баглаа боодлын эсрэг 2 тал дээр;   |
| 4 | 5 л эсхүл 5 кг -аас бага хэмжээгээр савлагдсан сав, баглаа боодолд | 100x100 мм буюу түүнээс доош   | Сав баглаа боодол бүр дээр;   |

<sup>2</sup> Аюулын зэрэглэлийг Нэгдсэн Үндэсний Байгууллага 1992 онд боловсруулсан бөгөөд таних тэмдгийг бараа материалын сав баглаа боодол дээр байршуулах шаардлагыг дэлхий нийтээр хэрэглэдэг.

5.3. Аюултай хог хаягдлыг ангилан хаяхдаа дараах төрлийн таних тэмдгийг ашиглана.



Зураг 14. Хортой хог хаягдал  
(Жишээ зураг)



Зураг 15. Химийн хог хаягдал  
(Жишээ зураг)



Зураг 16. Цөмийн хог хаягдал  
(Жишээ зураг)

## 6. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАН ЯЛГАХ, ТҮР ХАДГАЛАХ<sup>3</sup>

- 6.1. Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд учрах эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс аюултай хог хаягдлыг холихыг хориглоно.
- 6.2. Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдал хариуцсан орон тооны болон орон тооны бус ажилтантай байна.
- 6.3. Аюултай хог хаягдлыг ангилан ялгасан байх шаардлагатай бөгөөд зориулалтын саванд түр хадгална.
- 6.4. Аюултай хог хаягдлын ангилалд заасан төрлөөр ялгаж, зориулалтын уут, саванд түр хадгална. Зориулалтын уут, сав нь өнгөөр ялгаж төрөлжүүлсэн байх ба таних тэмдэгтэй байна.



Зураг 17. Эмнэлгийн үйлчилгээний хог хаягдал (Жишээ зураг)

Зураг 18. Химийн цацраг идэвхтэй хаягдал (Жишээ зураг)

Зураг 19. Халдварын зэрэглэл өндөртэй хаягдал (Жишээ зураг)

- 6.5. Ердийн болон тусгай хог хаягдлуудыг хооронд нь хольсон тохиолдолд уг хаягдлыг аюултай хог хаягдалд тавигддаг шаардлагын дагуу хадгална.
- 6.6. Аюултай хог хаягдлыг агуулах сав нь агуулж буй хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийгдсэн, эсхүл тийм материалаар доторлосон байх шаардлагатай.
- 6.7. Халдаггүй, зэвэрдэггүй, хортой материалаар хийгдээгүй байх ба сайтар таглаж, битүүмжлэх боломжтой байх шаардлагатай.

<sup>3</sup> Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж ялгах нь аюулын эрсдэлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд хүрээлэн байгаа орчин бохирдох, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.



Зураг 20. Аюултай хог хаягдал түр хадгалах сав (Жишээ зураг)

6.8. Аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

Аюултай хог хаягдлын талаарх  
мэдээлэл

Аюултай хог хаягдлын код: \_\_\_\_\_

Нэр: \_\_\_\_\_

Хэмжээ: \_\_\_\_\_

Хадгалж эхэлсэн огноо: \_\_\_\_\_



| Аюулын шинж чанар                 |  | Физик төлөв байдал              |                                |
|-----------------------------------|--|---------------------------------|--------------------------------|
| <input type="checkbox"/> Шатамхай | <input type="checkbox"/> Зэврэмтгий      | <input type="checkbox"/> Хий    | <input type="checkbox"/> Хатуу |
| <input type="checkbox"/> Хортой   | <input type="checkbox"/> Урвалд оромтгой | <input type="checkbox"/> Шингэн |                                |

| Аюултай хог хаягдал үүсгэгчийн мэдээлэл |                          |
|---|--------------------------|
| Бүртгэлийн дугаар: _____                | Нэр: _____               |
| Хаяг: _____                             | Холбоо барих утас: _____ |

Монгол улсын Хог хаягдлын тухай хуулиар аюултай хог хаягдлыг хууль бусаар хаях нь хориотой бөгөөд та энэхүү аюултай хог хаягдлыг ямар нэгэн байдлаар олсон бол энэхүү шошго дээр байгаа үүсгэгч, эсвэл холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ үү!

БОЛГООМЖТОЙ ХАРЬЦАНА УУ!

Зураг 21. Аюултай хог хаягдал хадгалах савны шошго (Жишээ зураг)

- 6.9. Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг дараах хугацаанд эх үүсвэр дээр түр хадгалж болно. Үүнд:
- 6.9.1. сард 1000 килограммтай тэнцүү буюу түүнээс бага аюултай хог хаягдал үүсгэдэг бол 180 хоног;
- 6.9.2. сард 1000 килограммаас их хэмжээтэй аюултай хог хаягдал үүсгэдэг бол 90 хоног.
- 6.10. Аюултай хог хаягдлыг агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална.
- 6.11. Гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг шаардлагатай газар байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангасан байна.




Зураг 22. Гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах жишээ (Жишээ зураг)

- 6.12. Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэх ба хог хаягдлын аюулын шинж чанар болон аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулсан байна.
- 6.13. Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байна (Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол, 2.2.5).
- 6.14. Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад дагалдах бичгийг бүрдүүлэн шилжүүлнэ (Хог хаягдлын тухай хууль, 23.6).
- 6.15. Үүсгэгч болон өмчлөгч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэхдээ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан маягтын дагуу аюултай хог хаягдлын дагалдах бичгийг бүрдүүлж, бүртгэл хөтөлнө.

## 7. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ <sup>4</sup>

7.1. Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын олгосон зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ (Хог хаягдлын тухай хууль, 24.1).



Зураг 23. Аюултай хог хаягдал цуглуулах болон устгах схем (Жишээ зураг)

- 7.2. Аюултай хог хаягдал тээвэрлэгч аюултай хог хаягдал үүсгэгчээс тэмдэг, тэмдэглэгээтэй зориулалтын саванд савласан, хог хаягдлын дагалдах бичигтэй аюултай хог хаягдлыг гэрээний үндсэн дээр хүлээн авч тээвэрлэнэ (Хог хаягдлын тухай хууль, 24.2).
- 7.3. Аюултай хог хаягдал тээвэрлэгч тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал болон аюултай хог хаягдлын сав баглаа боодол, тоо хэмжээний бүрэн бүтэн байдлыг хариуцна (Хог хаягдлын тухай хууль, 24.5).
- 7.4. Авто тээврийн хэрэгслээр зөвхөн өдрийн цагаар тээвэрлэнэ (Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол, 3.11.1).
- 7.5. Нийцгүй аюултай хог хаягдлыг хамт тээвэрлэхийг хориглоно.
- 7.6. Аюултай хог хаягдал тээвэрлэгч нь аюултай хог хаягдал тээвэрлэдэг тээврийн хэрэгслийг цэвэрлэх, ариутгах байгууламжтай байна.
- 7.7. Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрлийн дагуу зөвхөн тогтоосон маршрутын дагуу тээвэрлэнэ.

<sup>4</sup> Аюултай хог хаягдлыг зөвхөн зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллага тодорхой батлагдсан хуваарь төлөвлөгөөний дагуу цуглуулж тээвэрлэх бөгөөд зориулалтын устгалын байгууламжид хадгалах, устгах үүрэг хүлээнэ.

## 8. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА<sup>5</sup>

- 8.1. Аюултай хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлагыг MNS 4978:2017 (Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавигдах ерөнхий шаардлага) стандартыг хангасан байна.
- 8.2. Хог хаягдлыг халдваргүйжүүлэхэд хялбар, аюулгүй ачиж буулгахад тохиромжтой аюултай хог хаягдал зөөх тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлага хангасан битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- 8.3. Аюултай хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь нээлттэй тэвштэй, битүү бүхээгтэй, цистерн зэрэг тусгай зориулалтаар тоноглогдсон байна.



Зураг 24. Битүү бүхээгтэй тээврийн хэрэгсэл (Жишээ зураг)




Зураг 25. Цистерн тээврийн хэрэгсэл (Жишээ зураг)



Зураг 26. Нээлттэй тэвштэй тээврийн хэрэгсэл (Жишээ зураг)

- 8.4. Тээвэрлэгч тээврийн хэрэгсэл дээр аюултай хог хаягдлын анхааруулах тэмдгийг стандартад заасан байрлалд байрлуулсан байна.
- 8.5. Аюултай хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн урд болон ард “Аюултай ачаа” таних тэмдгийг MNS5029 стандартын дагуу байрлуулах ба баруун талын улбар шар дэвсгэрийн дээд хэсэгт аюулын болон сэрэмжлүүлэх тэмдэглэгээний код, доод хэсэгт НҮБ-ээс тогтоосон аюултай бодисын ангилалын дугаар (UN number) -г тэмдэглэнэ (MNS 4978:2017, 6.3).



Зураг 27. Аюултай ачаа таних тэмдгийн хэмжээ (Жишээ зураг)

- 8.6. Тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх хор уршгийг арилгах зориулалтын багаж, хэрэгсэл /галын хор, хүрз, лоом, сүх зэрэг багаж хэрэгсэл, шуудайтай элс, хувин гэх мэт/, хор саармагжуулах бодис, уусмалаар тээврийн хэрэгсэл бүрэн тоногдсон байна.

<sup>5</sup> Монгол Улс 1989 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн “Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц” -д нэгдсэн бөгөөд уг конвенцод “Аюултай болон бусад хог хаягдлыг хаягдал гаргагч нь байгаль орчныг хамгаалахад зохицсон аргаар тээвэрлэн зайлуулах арга хэмжээг улс орнууд авч байх ёстойг тэмдэглэж, аюултай болон бусад хог хаягдлыг анх гаргасан тухайн улсад нь байгаль орчинд аюулгүй байдлаар зайлуулах ёстой гэдгийн харилцан тохиролцсон байдаг.



8.7. Аюултай хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгсэл дор дурьдсан багаж хэрэгслийг заавал авч явна (MNS 4978:2017, 6.14).



Зураг 28. Орохыг хориглоно тэмдэг /2 ширхэг/ (Жишээ зураг)



Зураг 29. Галын хор (Жишээ зураг)



Зураг 30. Хувийн хамгаалах хэрэгсэл (Жишээ зураг)



Зураг 31. Дугуйн ивүүр 2-оос цөөнгүй (Жишээ зураг)

8.8. Шатамхай аюултай хог хаягдал тээвэрлэх машин нь тээвэрлэлтийн хугацаанд нийтийн хэрэглээний шатахуун түгээх станцаас түлш дүүргэхгүй байхаар цэнэглэх шаардлагатай.

## 9. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХҮЛЭЭН АВАХ <sup>6</sup>

- 9.1. Аюултай хог хаягдал хүлээн авах үйл ажиллагааг “Хог хаягдлын тухай хууль” -ийн 27 дугаар зүйл, “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, болон бүртгэх, тайлагнах журам” Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолоор батлагдсан журмын 5 дугаар бүлэгт зааснаар тус тус зохицуулна.
- 9.2. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь хог хаягдлыг хүлээн авахын өмнө төлөөлөх дээжид шинжилгээ хийж, шаардлагатай үзүүлэлтийг тодорхойлсон байна.
- 9.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авахдаа дагалдах бичигт (Хүснэгт 3) заасан хог хаягдал мөн эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгаж авна. (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/21 дугаар тушаал, 1 дүгээр хавсралт).
- 9.4. Хог хаягдлын дагалдах бичиг, хог хаягдлын тоо хэмжээ, төрөлд үл зохицол илэрвэл хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээж авахаас татгалзаж болно.
- 9.5. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хоосон саванд суллаж авах бөгөөд шахсан хий болон онцгой хортой химийн бодисоос бусад аюултай хог хаягдал савласан сав болон дотоод давхар савлагааны уутыг бэлтгэсэн байна.


<sup>6</sup> Аюултай хог хаягдлыг аюулгүй байдлаар хадгалах, устгах шаардлагатай тул зөвхөн зориулалтын байгууламжид зөвшөөрөгдсөн байгууллага аюулгүй байдлыг хангасан орчинд хүлээн авна.

## Хүснэгт 3. Аюултай хог хаягдлын дагалдах бичиг /маягт/

|   |                                  |             |
|---|----------------------------------|-------------|
| Дагалдах бичгийн дугаар:<br>(шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэ)   |                                  |             |
| <b>1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:</b><br>Бүртгэлийн дугаар:<br>Нэр:  |                                  |             |
| <b>2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:</b>   |                                  |             |
| Овог нэр (дармал үсгээр бичих)  | Гарын үсэг (тамга)               | Он сар өдөр |
| <b>3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:</b>   |                                  |             |
| Тээврийн хэрэгслийн улсын дугаар:   | Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар: |             |
| Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн нэр:  |                                  |             |
| Тээврийн хэрэгслийн улсын дугаар:   | Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар: |             |
| Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн нэр:  |                                  |             |
| <b>4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:</b>  |                                  |             |
|   |                                  |             |
| <b>5. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:</b>   |                                  |             |
| <b>6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч:</b>   |                                  |             |
| Овог нэр (дармал үсгээр бичих)  | Гарын үсэг (тамга)               | Он сар өдөр |
| Овог нэр (дармал үсгээр бичих)  | Гарын үсэг (тамга)               | Он сар өдөр |
| <b>7. Үл зохицол:</b>   |                                  |             |
| <b>8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:</b><br>Аж ахуй нэгжийн нэр:<br>Бүртгэлийн дугаар:<br>Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:<br>Овог нэр (дармал үсгээр бичих) Гарын үсэг (тамга) Он сар өдөр |                                  |             |

## 10. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАДГАЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ<sup>7</sup>


10.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхэлж, шаардлагын дагуу ажиллана.



Зураг 32. Аюултай хог хаягдлын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий байгууллагын үйл ажиллагааны зураглал (Жишээ зураг)


- 10.2. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа явуулж байгаа байгууламж нь онцгой байдлын зохицуулагчтай байна.
- 10.3. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанаас үүсэж болох аюул, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байна.
- 10.4. Аюултай эд анги агуулсан бүтээгдэхүүний хаягдал цуглуулах үйл ажиллагааг аюултай хог хаягдал хадгалах үйл ажиллагааны нэг хэлбэр гэж үзнэ.
- 10.5. Онцгой байдлын зохицуулагч аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрхтэй.
- 10.6. Аюултай хог хаягдал хадгалах агуулах нь Хог хаягдлын тухай хуулийн 25.3, MNS 6458:2014 стандарт, БНБД 31-19-10, 2010 барилгын норм ба дүрэм болон бусад шаардлагыг хангасан байх ба дараах байршилд байгуулахыг хориглоно.

<sup>7</sup> Аюултай хог хаягдал үүсгэгч нь хог хаягдлын хэмжээг бууруулах, эргүүлэн ашиглах, хоргүйжүүлэх, устгах замаар байгаль орчинд ялгарах ялгарал, бохирдуулагчийн хэмжээг бууруулах бөгөөд дахин боловсруулах боломжгүй тохиолдолд аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, экспортлох зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх үүрэгтэй.



Зураг 33. Агуулахын байршлын төлөвлөлт (Жишээ зураг)

10.7. Аюултай хог хаягдал нь дараах зурагт үзүүлсэн нөхцөлийг хангасан бол задгай агуулахад хадгалж болно (MNS 6458:2014).



Зураг 34. Задгай агуулахад хадгалах аюултай хог хаягдал (Жишээ зураг)

10.8. Агуулахын ажилтан дараах нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангагдсан байна.

Үүнд:

- 10.8.1. хамгаалалтын гутал;
- 10.8.2. химийн бодист тэсвэртэй хамгаалалтын хувцас;
- 10.8.3. хамгаалалтын малгай;
- 10.8.4. хамгаалалтын нүдний шил;
- 10.8.5. химийн бодист тэсвэртэй бээлий;
- 10.8.6. нүүрний баг;
- 10.8.7. амьсгал хамгаалах баг .



Зураг 35. Хувийн хамгаалах хэрэгсэл (Жишээ зураг)


- 10.9. Аюултай хог хаягдлыг юүлэх болон нэмэхээс бусад тохиолдолд савыг байнга таглаж битүү байлгана.
- 10.10. Аюултай хог хаягдалтай савыг онгойлгох, зөөх, ачиж буулгах, хадгалахдаа эвдэрч гэмтэх, хог хаягдал асгарахаас сэргийлж, аюулгүй ажиллагааг хангасан байна.
- 10.11. Аюултай шингэн хог хаягдал хадгалах сав байрлуулах талбай нь стандартын шаардлагыг хангасан хязгаарлалтын системтэй байх ба хязгаарлалтын системийн суурь нь эвдрэл гэмтэл, завсар зайгүй, асгарсан, алдагдсан хаягдал, хуримтлагдсан хур тунадасны усыг тогтоон барих боломжтой хаалт, хашилттай байна.
- 10.12. Алдагдсан, хуримтлагдсан шингэнийг тогтоон барих хязгаарлалтын системийн эзлэхүүн нь уг суурин дээр байрласан савнуудын нийт эзлэхүүнээс, эсхүл хамгийн том савны эзлэхүүнээс 10 хувиар их байна.
- 10.13. Алдагдсан, хуримтлагдсан шингэнийг хальж алдагдахаас урьдчилан сэргийлж, хураагуур болон хязгаарлалтын системд хуримтлагдсан шингэнийг тухай бүр нь зайлуулж байна.

- 10.14. Аюултай хуурай хог хаягдал хадгалах сав байрлуулах талбай нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 10.14.1. талбайн суурь нь налуу байх, эсхүл хуримтлагдсан хур тунадсыг зайлуулах, шавхах боломжтой байхаар төлөвлөгдөж, хийгдсэн байх;
  - 10.14.2. хур тунадас, нарны шууд тусгалаас хамгаалсан дээвэртэй байх.
- 10.15. Шатамхай болон урвалын идэвхтэй хог хаягдал хадгалах савыг байгууламжийн доторх барилга байгууламжаас 15 метрээс багагүй зайд байрлуулна.
- 10.16. Нийцгүй хог хаягдал хадгалж байсан савыг цэвэрлэлгүйгээр өөр хог хаягдал савлахад ашиглаж болохгүй.
- 10.17. Нийцгүй хог хаягдал хадгалж байгаа савыг бусад хог хаягдал хадгалдаг савтай ойр байрлуулсан тохиолдолд далан, суваг, хана гэх мэтээр тусгаарлаж, эрсдэл үүсэхээс хамгаалсан байна.
- 10.18. Аюултай хог хаягдлыг хадгалах сав байрлаж байгаа газарт 7 хоногт нэгээс доошгүй удаа үзлэг, шалгалт хийж, асгаралт, алдагдал, эвдрэл гэмтэл, элэгдэл, зэврэлт гарсан эсэхийг тогтоож байх шаардлагатай.

## 11. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ


*Аюултай хог хаягдлыг аюулгүй устгах гол зорилготой бөгөөд үйл ажиллагаа нь нарийвчилсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийгдэж аюулгүй ажиллагааг хангасан байх шаардлагатай.*

- 11.1. Аюултай хог хаягдлыг ландфиллд булшлах болон шатаах аргаар устгана.
- 11.2. Аюултай хог хаягдлын ландфилл нь хог хаягдал, түүнээс үүсэх шүүрлээс хөрс, газрын доорх болон гадаргын ус бохирдохоос хамгаалах зориулалттай доторлогооны систем, шүүрэл цуглуулах, зайлуулах системтэй байна.



Зураг 36. Аюултай хог хаягдлын ландфилл (Жишээ зураг)

- 11.3. Ландфиллд булшилж устгах аюултай хог хаягдалд дараах төрлийн хог хаягдлыг устгахыг хориглоно (Хог хаягдлын тухай хууль, 34.9). Үүнд:
- 11.3.1. шатамхай болон урвалын идэвхтэй хог хаягдал;
  - 11.3.2. хүн, малын эмнэлэг, эрүүл мэндийн төвийн эмчилгээ, сувилгаанаас үүссэн, эрүүл мэндийн байгууллагаас халдваргүйжүүлээгүй хог хаягдал;
  - 11.3.3. савлагаагүй шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал;
  - 11.3.4. судалгаа, шинжилгээ, сургалтын явцад үүссэн, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөлөл нь тогтоогдоогүй шинэ, эсхүл шинж чанар нь судлагдаагүй химийн бодисын хаягдал;
  - 11.3.5. хоорондоо нийцгүй хог хаягдлыг нэг дор, нэг үүрэнд хамт булшлах.
- 11.4. Дараах шингэнээс бусад бүх төрлийн шингэнийг ландфиллд булшлахыг хориглоно. Үүнд:
- 11.4.1. чөлөөт шингэнийг зайлуулсан, шингээгчид шингээсэн эсхүл хатууруулж бэхжүүлсэн;
  - 11.4.2. 50 мл -ээс бага савлагаатай;
  - 11.4.3. шингэн хадгалах зориулалтгүй, шингэн болон түүнийг агуулсан сав нь хамтдаа нэг зорилгоор ашиглагддаг батарей, аккумулятор зэрэг шингэн агуулсан сав;
  - 11.4.4. 1 литрээс бага хэмжээтэй давхар савлагаатай шингэн.
- 11.5. Аюултай хог хаягдал шатаах үйл ажиллагаа эрхлэгч нь туршилтын шатаалт хийж, үйл ажиллагааны горим, технологийн үзүүлэлтийг тогтооно.
- 11.6. Аюултай хог хаягдал шатаах зуух нь зуухны үйл ажиллагаа доголдох үед хог хаягдал ачаалах үйлдлийг зогсоох автомат системтэй байна.
- 11.7. Аюултай хог хаягдал шатаах зуух нь шаталт болон ялгаралд хяналт тавих төхөөрөмжтэй байна.




Зураг 37. Аюултай хог хаягдал шатаах зуух (Жишээ зураг)

- 11.8. Зууханд өгөх хог хаягдлын ачаалалт болон зуухны бүтцэд өөрчлөлт гарах, зуухны үйл ажиллагааны үзүүлэлт зөвшөөрөгдсөн хязгаараас давсан тохиолдолд зуухны үйл ажиллагааг зогсооно.
- 11.9. Аюултай хог хаягдал дахин боловсруулах, устгах байгууламжийн хий цэвэрлэх системээс үүссэн тоос, зуухны доод үнс зэрэг хатуу хаягдлыг зохих технологийн дагуу боловсруулж, аюултай хог хаягдлын ландфилл-д булж устгана.

## 12. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ<sup>8</sup>

- 12.1. Эрүүл мэндийн байгууллагаас үүссэн тусгай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 8.3, Эрүүл мэндийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2011 оны А-320/305 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах түр журам”, “Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158 дугаар тушаал”-ын дагуу тус тус зохицуулна.



Зураг 38. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ангилал (Жишээ зураг)

- 12.2. Ердийн болон тусгай хог хаягдлуудыг холихыг хориглоно. Хэрэв хольсон тохиолдолд уг хаягдлыг тусгай хог хаягдалд тавигддаг шаардлагын дагуу савлаж, хадгална.

|                                  |                                  |                                  |                           |
|----------------------------------|----------------------------------|----------------------------------|---------------------------|
|                                  |                                  |                                  |                           |
| Халдварын зэрэг өндөртэй хаягдал | Халдвартай хог хаягдал           | Эмийн хог хаягдал                | Цацраг идэвхт хог хаягдал |
|                                  | Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал | Химийн бодисын хог хаягдал       | Даралтат сав              |
|                                  | Эмгэг хог хаягдал                | Эсэд хортой нөлөөтэй хог хаягдал | Хүнд металлын хог хаягдал |

Зураг 39. Эмнэлгийн хог хаягдлыг ангилан ялгах уут, савны өнгө (Жишээ зураг)

<sup>8</sup> Эрүүл мэндийн байгууллагаас үүсэж байгаа хог хаягдлыг ердийн болон тусгай гэж ангилах бөгөөд тусгай хог хаягдал нь цуглуулах, устгахад тусгай шаардлага тавигддаг халдвартай хаягдалд хамаарна.



- 12.3. Эрүүл мэндийн бүх шатны байгууллага нь эмнэлгийн тусгай хог хаягдлыг ангилах, ялгах, цуглуулах, савлах, хадгалах, түр байршуулах, халдваргүйтгэх, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.
- 12.4. Эрүүл мэндийн байгууллагууд хог хаягдлыг түр хадгалах шаардлага хангасан байр, хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтэн, хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх үүрэг бүхий ажилтантай байна.
- 12.5. Эмнэлгийн хог хаягдлыг долоо хоногт 3-аас доошгүй удаа тээвэрлэн зайлуулах бөгөөд хог хаягдал гарсан цэгээс эцсийн цэг хүртэлх тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй халдвар, сөрөг нөлөөллөөс сэргийлэх үүргийг тээвэрлэгч хүлээнэ.
- 12.6. Эрүүл мэндийн байгууллагад үүссэн тусгай хог хаягдлыг ангилал тус бүрд тохирсон аргаар халдваргүйтгэж устгана.

Үүнд:

- 12.6.1. өндөр даралттай уураар халдваргүйтгэх;
- 12.6.2. бичил долгионоор халдваргүйтгэх;
- 12.6.3. зориулалтын шатаах зууханд өндөр температурт шатаах (1100°C-аас дээш температур);
- 12.6.4. эрүүл ахуйн шаардлага хангасан булах цэг ландфилл-д хаяж, өдөр тутам хөрсөөр хучих;
- 12.6.5. булах, булшлах.



Зураг 40. Эмнэлгийн тусгай хог хаягдал устгах үйл ажиллагаа (Жишээ зураг)

### 13. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын аюултай хог хаягдлыг хадгалах болон устгах байгууламжид тавигдах ерөнхий шаардлагыг хангаж байгаа эсэхийг Хүснэгт 4 -ийн дагуу хянан шалгана.

Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлт

| №  | Шалгуур үзүүлэлт   | Тийм                     | Үгүй                     |
|----|--|--------------------------|--------------------------|
| 1  | Аюултай хог хаягдал хадгалах агуулах болон устгах байгууламж нь холбогдох хууль, дүрэм, журам, барилгын норм ба дүрэм болон бусад шаардлагыг хангасан байршилд байрласан эсэх  | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2  | Аюултай хог хаягдал хадгалах агуулах болон устгах байгууламж, барилга байшин, далан суваг, хураагуур гэх мэт барилгын бүтэц хэсгийн ашиглалт болон бүрэн бүтэн байдал хангагдсан эсэх  | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3  | Аюул ослоос урьдчилан сэргийлэх, түүнийг мэдрэх, хариу арга хэмжээ авах зориулалттай хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмж тоноглол, дохиоллын системтэй эсэх   | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4  | Байгууламжийн доторх замын хөдөлгөөний зураглал, замын хөдөлгөөний тэмдэг тэмдэглэгээ, дохио, замын хучилт ба даац нь стандарт шаардлага хангаж байгаа эсэх  | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 5  | Аюултай хог хаягдлын асгаралт, алдагдлыг барих, сааруулахад ашиглагдах арга технологи, техник, тоног төхөөрөмж, дэд бүтцээр хангагдсан эсэх  | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 6  | Аюултай хог хаягдлын байгууламж дахь хур борооны ус зайлуулах, үерээс хамгаалах, шугам хоолой бохирдол цэвэрлэх, хуримтлагдсан шингэнийг зайлуулахад ашиглагдах арга технологи, техник, тоног төхөөрөмж, дэд бүтцээр хангагдсан эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 7  | Аюултай хог хаягдлын байгууламж дахь тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, цахилгаанаас үүдэлтэй нөлөөллийг бууруулах, ертөлтөөс ажилтныг хамгаалахад ашиглагдах арга технологи, техник, тоног төхөөрөмж, дэд бүтцээр хангагдсан эсэх    | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 8  | Аюултай хог хаягдлын байгууламж дахь агаарт ялгарах ялгарлыг бууруулахад ашиглагдах арга технологи, техник, тоног төхөөрөмж, дэд бүтцээр хангагдсан эсэх   | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 9  | Шатамхай, урвалын идэвхтэй, нийцгүй хог хаягдлаас үүсэж болох аюул ослоос урьдчилан сэргийлэх арга технологи, техник, тоног төхөөрөмж, дэд бүтцээр хангагдсан эсэх   | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 10 | Ландфиллын шүүрлийг бууруулах хариу арга хэмжээний арга технологи, техник, тоног төхөөрөмж, дэд бүтцээр хангагдсан эсэх  | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

**Тайлбар:** Аюултай хог хаягдлыг хадгалах болон устгах байгууламж нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.






Бусад тохижилт бүтээн байгуулалтад хамаарах зүйлсийг Хотын стандартын баримт бичгийн тогтолцоонд хамаарах хүлээн авах шалгуурын дагуу шалгаж хүлээн авна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Хог хаягдлын тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр (Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны 298 дугаар тогтоол)
- Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар тушаал) Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам (Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол)
- Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа, эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавих, шаардлага болон зөвшөөрөл олгох журам (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/18 дугаар тушаал)
- Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах түр журам (Эрүүл мэндийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2011 оны А-320/305 тоот тушаал)
- Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах заавар (Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158 тоот тушаал)
- MNS 6458:2014. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис хадгалах бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага
- MNS 5029:2011. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодсын шошго, анхааруулах тэмдэг
- MNS 5566:2005. Аж ахуй нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага
- MNS ISO 3833:2010. Авто тээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт
- MNS 6593:2016. Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэлт. Нэр томьёо, тодорхойлолт
- MNS 4978:2017. Аюултай ачаа. Ангилал.Техникийн ерөнхий шаардлага
- MNS 4596:2014. Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм
- MNS 4643: 1998. Хөдөлмөр хамгаалал. Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө
- БНБД 21-01-02. Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм дүрэм

**ХАВСРАЛТ 1. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН АНГИЛАЛ**

Хүснэгт 5. Аюултай хог хаягдлын ангилал

| Тэмдэг   | Ангилал  | Нөлөөлөл                                 |
|--|--|--|
|       | Тогтворгүй тэсрэмтгий  | HP1 Тэсрэмтгий                           |
|  | Тэсрэмтгий, ангилал 1.1, 1.2, 1.3, 1.4                         |  |
|  | Өөрөө урвалд орогч нэгдлүүд ба холимогууд, төрөл А, В          |  |
|       | Органик хэт исэлүүд, төрөл А, В                                | HP2 Исэлдүүлэгч                          |
|  | Исэлдүүлэгч хий, ангилал 1                                     |  |
|  | Исэлдүүлэгч шингэн, ангилал 1, 2, 3                            |  |
|      | Исэлдүүлэгч, ангилал 1, 2, 3                                   | HP3 Шатамхай                             |
|  | Шатамхай хий, ангилал 1  |  |
|  | Шатамхай аерозоль, ангилал 1, 2                                |  |
|  | Шатамхай шингэн, ангилал 1, 2, 3                               |  |
|  | Шатамхай хатуу, ангилал 1, 2                                   |  |
|  | Өөрөө урвалд орогч нэгдлүүд ба холимогууд, төрөл В, С, D, E, F |  |
|  | Пирофор шингэн, ангилал 1                                      |  |
|  | Пирофор хатуу, ангилал 1                                       |  |
|  | Өөрөө халдаг орогч нэгдлүүд ба холимогууд, ангилал 1, 2        |  |
| Устай холиход/холидоход шатдаг хий ялгаруулагч нэгдлүүд ба холимогууд, ангилал 1, 2, 3 |  |  |
| Тэмдэг байхгүй   | Органик хэт исэлүүд, төрөл В, С, D, E, F                       | HP15                                     |
|  | Тэсрэмтгий, ангилал 1.5, 1.6                                   | HP3 Шатамхай                             |
|  | Шатамхай хий, ангилал 2  | Тодорхойгүй                              |
|  | Өөрөө урвалд орогч нэгдлүүд ба холимогууд, төрөл G             | Тодорхойгүй                              |
|     | Органик хэт исэлүүд, төрөл G                                   | Тодорхойгүй                              |
|  | Даралттай хий  | Даралтад хий (аюулын шинж чанар байхгүй) |
|  | Шингэрүүлсэн хий   |  |
|  | Хөргөсөн, шингэрүүлсэн хий                                     |  |
| Уусгасан хий   |  |  |
|     | Арьс өрөвсүүлэгч, ангилал 1A                                   | HP 4 Цочроогч                            |
|  | Арьс өрөвсүүлэгч, ангилал 1B болон 1C                          | HP 8 Зэврүүлэгч                          |
|  | Нүд ноцтой гэмтээгч, ангилал 1                                 | HP 4 Цочроогч                            |
|  | Металлуудад идэмхий  | Тодорхойгүй                              |

|   |   |   |
|---|---|---|
|    | Онцгой хортой (амаар, арьсаар, амьсгалаар), ангилал 1, 2, 3   | HP 6 Онцгой хортой  |
|    | Амьсгалын замыг цочроодог, ангилал 1  | HP 12 Мэдрэмтгий  |
|   | Үр хөврөлийн эсийн мутагенд оруулдаг, ангилал 1A, 1B, 2   | HP 13 Мутаген   |
|   | Хорт хавдар үүсэх магадлалыг нэмэгдүүлдэг, ангилал 1A, 1B, 2  | HP 7 Хорт хавдар үүсгэгч                                  |
|   | Нөхөн үржих чадварыг бууруулдаг, ангилал 1A, 1B, 2  | HP 10 Нөхөн үржихүйд хортой                               |
|   | Нэг удаагийн үйлчлэлээр тодорхой эрхтэнийг хордуулагч, ангилал 1, 2   | HP 5 Тодорхой эрхтэнд хортой/<br>Амьсгалын эрхтэнд хортой |
|   | Давтан үйлчлэлээр тодорхой эрхтэнийг хордуулагч, ангилал 1, 2   |   |
|   | Амьсгалахад хөнөөлтэй, ангилал 1, 2   |   |
|   | Онцгой хортой (амаар, арьсаар, амьсгалаар), ангилал 4   | HP 6 Онцгой хортой  |
|   | Арьс цочроогч, ангилал 2, 3   | HP 4 Цочроогч   |
|   | Нүд цочроогч, ангилал 2A  |   |
|   | Арьсанд мэдрэмтгий, ангилал 1   | HP 12 Мэдрэмтгий  |
| Тэмдэг байхгүй  | Нэг удаагийн үйлчлэлээр тодорхой эрхтэнийг хордуулагч, ангилал 3  | HP 5 Тодорхой эрхтэнд хортой/<br>Амьсгалын эрхтэнд хортой |
|   | <ul style="list-style-type: none"> <li>• Амьсгалын замыг цочроогч</li> <li>• Мансууруулах нөлөөтэй</li> </ul> |   |
| Тэмдэг байхгүй  | Онцгой хортой (амаар, арьсаар, амьсгалаар), ангилал 5   | Тодорхойгүй   |
|   | Нөхөн үржих чадварыг бууруулдаг – хөхөөр хооллох үед дамжин нөлөөлдөг   | Тодорхойгүй   |
|  | Усан орчинд аюултай – Усан орчинд маш аюултай ангилал 1   | HP 14 Экотоксик (хүрээлэн буй орчинд хортой)              |
|   | Усан орчинд аюултай – Усан орчинд удаан хугацаанд аюултай ангилал 1, 2  |   |
|  | Озоны давхаргад аюултай   |   |
| Тэмдэг байхгүй  | Усан орчинд аюултай – Усан орчинд маш аюултай ангилал 2, 3  |   |
|   | Усан орчинд аюултай – Усан орчинд удаан хугацаанд аюултай ангилал 3, 4  |   |

## ТЭМДЭГЛЭЛ

Blank page with horizontal dotted lines for writing.





Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Наадамчдын зам 1200, Арцатын ам, 4 дүгээр хороо,  
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100



70118030, 70118040



[www.standard.ub.gov.mn](http://www.standard.ub.gov.mn)



Хотын стандарт, хяналтын газар